



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА Г.ЛХАГВАХАТАН ТАНАА

2021.10.10 № 9/2409
таний -ны № -т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 9 дүгээр сарын 20-д тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хяналтад аваагүйн улмаас дээд газраас ирүүлсэн тайлангийн маягтын дагуу тухайн үед нь гаргаж явуулдаг, бүртгэл байхгүй. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилтот түвшнийг тодорхойлоогүй хоосон орхисон заалтууд байгаа бөгөөд суурь түвшин, хүрэх түвшинг бодлогын баримт бичигтэй уялдуулаагүй, шалгуур үзүүлэлтийг буруу тодорхойлсон байгаа тул төлөвлөлтөө нягталж сайжруулах шаардлагатай гэж дүгнэж байна.

Зөвлөмж:

1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн холбогдох заалтуудыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10 дугаар зүйлийн 10.7-д заасны дагуу хяналтад авч, жил бүр жагсаалтыг шинэчлэн агентлагийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах

2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцах нэгжтэй бол хариуцах нэгжийг, нэгжгүй бол хариуцах эзэнг тодорхой бичих, нэгжтэй бол байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс салгаж авсан нэгжийн төлөвлөгөөтэй болох

3.Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтын дагуу мэргэжилтнүүд албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ гүйцэтгэлийн

2.

төлөвлөгөөнд бүрэн багтаасан эсэхийг дахин нягтлах, үнэлгээний хуудсыг үнэн зөв бөглөх

4.Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах, цагийн бүртгэлд сар бүр хяналт тавьж, хяналтын хуудасны хэрэгжилтийг хангаж ажиллах, хувийн хэрэг хөтлөлтийн хувьд Төрийн албаны зөвлөлийн 5 дугаар тогтоолын дагуу зарим албан хаагчдын хувь хүний намтрыг баяжуулах, төрийн жинхэнэ албанд орсон тухай нотлох баримт бичгийг нэмж оруулах

5.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлж ажиллах

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 28-ний дотор ирүүлнэ үү.



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Огноо: 2022 он... сар... өдөр

№	Хамрах хүрээ	Дүн/хувиар/
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тэдгээрийг хяналтад авсан байдал	30
2	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт	—
3	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөлт	100
4	Байгууллагын дарга болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, жилийн ажлын төлөвлөгөө, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо	70
5	Салбарын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээ	—
6	Төрийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт	90
7	Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилт	90
8	Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, түүний ажлын төлөвлөлттэй уялдсан байдал	90
9	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын хэрэгжилт	90
ДҮН		80

Ажиллах хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн

ахлагч: ХШҮХ-ийн дарга

Ц.Ганчимэг

Гишүүд: ХШҮХ-ийн мэргэжилтэн

Г.Уянга

СТСХ-ийн мэргэжилтэн

Г.Ариунхүү

ТЗҮХ-ийн мэргэжилтэн

С.Лхагвацэрэн

Танилцсан:

Орон нутгийн өмчийн газрын дарга

Г.Лхагвахатан

